



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/102

Арвайхээр

**Хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.17, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 42 дугаар зүйлийн 42.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа боловсролын 31 сургууль, 44 цэцэрлэгийн байгууллагуудын үйл ажиллагааг 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлүүлсэнтэй холбоотой ариутгал халваргүйтгэлийн зардалд 42,037,200 (дөчин хоёр сая гучин долоон мянга хоёр зуун ) төгрөг зарцуулсугай.

2.Дээрх арга хэмжээнд зарцуулах 42,037,200 ( дөчин хоёр сая гучин долоон мянга хоёр зуун ) төгрөгийг Гамшгаас хамгаалах зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А. ИШДОРЖ

011100224